

АГУУЛГА

Нэг. Төслийн товч танилцуулга	3
Хоёр. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	5
2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчны төлөв байдал	5
2.2. Нийгэм-эдийн засаг	6
Гурав. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	7
Дөрөв. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	8
Тав. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
Зургаа. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	11
Долоо. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
Найм. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	13
Ес. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Арав. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
Арван нэг. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	17
Арван хоёр. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	18
Дүгнэлт. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн байршлын тойм зураг.... 4

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих газрын захын цэгүүдийн солбицол	4
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд ..	9
Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	11
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	13
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	16
Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	17
Хүснэгт 9. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь	18
Хүснэгт 10. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	19

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”

Төслийн зорилго: Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори нь хөрс, ус, ургамал, үр тариа болон бордооны дээжүүдэд физик химийн найрлага, шинж чанар, эрүүл ахуйн үзүүлэлтүүд болон бохирдлыг химийн, физикийн, физик химийн болон орчин үеийн багажит шинжилгээний аргуудыг ашиглан тодорхойлохоос гадна үнэн зөв, нарийвчлал сайтай арга аргачлалыг задлан шинжилгээндээ ашиглан, түргэн шуурхай лабораторийн үйлчилгээг үйлчлүүлэгчиддээ хүргэх зорилготой ажилладаг.

Төслийн үндсэн үйл ажиллагаа: “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори” нь дээрх зорилгын хүрээнд хөрс, ус, ургамал, үр тариа болон бордооны дээжүүдэд дараах шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Хөрсөнд физикийн, химийн болон хүнд металлийн шинжилгээ
- Ургамлын биохимийн шинжилгээ
- Усны иж бүрэн шинжилгээ
- Хөрс, усны эрүүл ахуй, нян судлалын шинжилгээ
- Бордооны эрдсийн болон шим тэжээлийн шинжилгээ
- Үрийн физик химийн шинж чанарын шинжилгээ зэрэг багтана.

Дээрх шинжилгээнүүдийг хөдөө аж ахуй, газар тариалан, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон судалгаа, шинжилгээний ажил, бусад төсөл хөтөлбөрт ашиглахад зориулан иргэд, аж ахуйн нэгжүүд, эрдэмтэн судлаачид хийлгэж байна.


Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл: “Нарт ШУҮН консалтинг” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011537038, Регистрийн дугаар: 5943043

“Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгчийн үндсэн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, 18-15 тоот “Нарт ШУҮН консалтинг” ХХК, Утас: 86050516, 89025610

Төслийн байршил: “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори” нь Сонгинохайрхан дүүргийн 23-р хорооны нутагт, 21-р хорооллын ДЕПО-гийн

автобусны буудлын зүүн талд “Цахилгаан тээвэр” компанийн хашааны урд,
“Талх чихэр” ХК-ийн хойно Драгон төвөөс хойш 21-р хороолол өгсөх төв замаас зүүн
тийш 250 метрийн зайд байрлаж байна.



Зураг 1. “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн байршлын тойм зураг

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих газрын захын цэгүүдийн солбицол

№	X	Y
1	47° 54' 57.633"	106° 49' 17.534"
2	47° 54' 58.534"	106° 49' 17.425"
3	47° 54' 58.584"	106° 49' 18.130"
4	47° 54' 57.676"	106° 49' 18.261"

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчны төлөв байдал

Агаар орчин: “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн төсөл хэрэгжиж буй талбай нь Сонгинохайрхан дүүргийн 23-р хорооны нутаг дэвсгэрт, Сүлжмэл-21-р хороолол-Баянхошуу чиглэлийн төв замаас зүүн тийш 250 метрийн зайнд орших ба 1-р хорооллын арын гэр хорооллын дундах засмал зам дагуу байрлаж байна. Энд өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй байх ба сүүлийн жилүүдэд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах төслийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангаж байгаа нь нийслэлийн гэр хорооллын зүгээс хийсч дунд гол орчимд тогтдог утаа, агаарын бохирдол харьцангуй бага болж байна. Агаар бохирдуулагч хүчин зүйл нь хүйтний улиралд дулааны цахилгаан станц болон гэр хорооллын галлагаатай холбоотой. Мөн сүүлийн жилүүдэд автомашины тоо олноор нэмэгдэж байгаа нь хотын агаарын бохирдол ихсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Хөрсөн бүрхэвч: Улаанбаатар хотын газар нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын Хангайн их мужийн өндөршлийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт багтана. Төсөл хэрэгжих талбай байрлах 21-р хороолол, Баянхошуу орчмоор уулын хар хүрэн хөрс, хар хүрэн хөрс, нугын ердийн хөрс тархсан бөгөөд хөрс судлалын лаборатори нь хар хүрэн хөрстэй газарт байрлаж байна.

Байгаль орчны төлөв байдлын судалгаагаар “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хашааны сул чөлөөтэй хэсгийн хөрс халцарч доройтсон байна. Төслийн талбайгаас дээж авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын лабораторит задлан шинжлүүлэхэд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, үржил шим сайтай хөрстэй байна. Мөн хөрсний бохирдол тодорхойлох шинжилгээгээр хүнд металлуудын агууламж “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандартад зааснаас бага буюу бохирдолгүй байна.

Усан орчин: “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори” нь Улаанбаатар хотод байрлах тул Туул голын сав газарт харъяалагдана. “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хөрс судлалын лаборатори байрлаж буй газрын баруун болон урд талаар өмнө нь Толгойт гол урсдаг. Толгойт голын урсацын хэмжээ сүүлийн жилүүдэд

Улаанбаатар хотын суурьшлын бүсийн тэлэлт болон уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан багассаар байна. Иймд Толгойт голын хуучин гольдролын дагуу Баянхошуу, Толгойт, 21-р хороолол, 1-р хорооллын суурьшлын бүсэд үерийн далан байгуулсан байна. Тус үерийн далан нь “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хөрс судлалын лабораторийн урд талд 60 метр зайд байрлаж байна.

Харин “Нарт ШУҮН консалтинг” ХХК нь Улаанбаатар хотын төвийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон тул шугамын уснаас авсан усыг шинжилгээнд хамруулахад химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус гэж гэсэн дүгнэлт гарсан. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”-ын шаардлага хангаж байна.

Ургамлан нөмрөг: “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ийн хөрс судлалын лаборатори байрлаж буй Улаанбаатар хот нь Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамрагдаж байна. Хээрийн судалгаагаар лабораторийн зүүн талд улиангар, гацуур, шар хуайс, улиас тарьж модон саадаар хамгаалсан хэсэгт ургамлын бүрхэц 95-98%, ургамлын дундаж өндөр 20-25 см байна. Лабораторийн хашаа нь 5122.0 м² газрыг хамрах бөгөөд зам талбай, барилгад өртөөгүй 3221.9 м² сул чөлөөтэй талбайн хөрс халцарч доройтон ургамалгүй болсон байна. Төслийн талбайн хашаалж хамгаалаагүй хэсэгт замын таван салаа, зэл зангуу, халгай зэрэг хөл газрын ургамлууд ургаж байна.

2.2. Нийгэм-эдийн засаг

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болох тус хороо нь 2007 онд Сонгинохайрхан дүүргийн 6-р хорооноос салж шинээр байгуулагдаж Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 23 дугаар хороо нэртэйгээр байгуулагдсан.

2019 оны 06 сарын 10-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25/21 дугаар тоот тогтоолоор 23 дугаар хороо нь шинээр байгуулагдсан 39, 37 дугаар хороодод газар нутаг, хүн ам, хилийн цэст өөрчлөлт орсон. Шинэчлэгдсэн 23 дугаар хороо 1,2 га газар нутагтай, 1638 өрх, 6650 хүн амтай бөгөөд хойд талаараа 39 дүгээр хороо, урд талаараа 29 дүгээр хороо, зүүн талаараа 30, дугаар хороо, баруун талаараа 37,6 дугаар хороодтой зааглагддаг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн үйл ажиллагаанаас голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлон үзүүлэв.

Агаарын бохирдолт: Тус лаборатори нь дулаан хангамжийн асуудлаа төвийн нэгдсэн дулааны шугам сүлжээнд холбогдож шийдвэрлэсэн бөгөөд төслийн талбайн зүгээс агаарын бохирдолд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Хөрс ба ургамалжилтад нөлөөлөх: “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн төслийн талбайд үйлдвэрийн барилга байгууламж баригдаж зам талбайг хатуу хучилттай болгосон тул цаашид төслийн зүгээс хөрс, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Гадаргын болон гүний усанд нөлөөлөх: Төслийн талбайд гадаргын ил задгай гол, горхи, булаг шанд байхгүй юм. Тус төслийн хувьд үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний усаа төвийн шугам сүлжээнээс хангадаг ба үйлдвэрээс гарч буй шингэн хаягдлыг төвийн бохир усны нэгдсэн сүлжээнд нийлүүлдэг. Иймд гадаргын болон газрын гүний усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Амьтны аймагт нөлөөлөх: Төсөл хэрэгжиж буй газар нь олон жилийн туршид хүний үйл ажиллагаанд өртсөн, эргэн тойрон нь барилгажсан, олон хөлийн газар тул тухайн орчинд төрөл бүрийн ан амьтан байхгүй. Өөрөөр хэлбэл төслийн үйл ажиллагаанаас ан амьтанд учруулах сөрөг нөлөөлөлгүй гэж үзэж болно.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт нь энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул дээрх сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэж ажиллана.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Нарт ШУҮН Консалтинг” ХХК нь “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд БОННУ-ий тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах талаар явуулах үйл ажиллагаа нь дараах талбаруудад чиглэгдвэл зохино. Үүнд:

- Төслийн бүх ажлыг аюулгүй ажиллагааны дүрмийн заалтын дагуу хийх
- Лабораторийн ажлыг зохих технологийн дагуу, техникийн удирдагчийн удирдлагын дор явуулах ба техникийн удирдагчгүйгээр явуулахыг хориглоно.
- Ургамалжуулсан талбай, түүний хүрээлэн буй орчин нь байгалийн тэнцвэрт байдлыг хадгалсан хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх
- Төслийн талбайн орчинд галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах булан байгуулах
- Төслийн талбайд ашиглалтын улмаас үүссэн болон ахуйн хог хаягдлыг цаг тухайд нь цэвэрлэх
- Гал түймрээс сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллах
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгааг ажиллагсдад бүрэн өгч, гал түймрийн үед ажиллах зохион байгуулалт хийж мөрдөх, түүнчлэн хөрсийг ус ба салхины нөлөөгөөр элэгдэл эвдрэлд орохоос хамгаалж тарималжуулах болон бусад хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай.
- Эвдэрсэн газрыг ургамалжуулах ургамлын төрөл зүйл, тариалах арга ажиллагааг тухайн хөрсний шинж чанар бүтэц болон газрын гадаргын налуу болон бусад нөхцөл байдалтай уялдуулан сонгох бөгөөд үр суулгац тариалах ажлыг ургамал ургах хамгийн тохиромжтой хугацаанд явуулбал зохино.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, мян. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1.	Химийн бодис хадгалах өрөө болон шинжилгээ судалгаа, дээжийн задаргаа хийх өрөөнүүдийн агааржуулалтын ажиллагаа доголдсоноос бодис уурших, халах, тэлэх нөхцөл үүсч болзошгүй.	Агааржуулалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг байнга анхаарч, засвар үйлчилгээ, шинэчлэлийг тухай бүр хийж байх	Задаргааны, шинжилгээний болон химийн бодис хадгалах өрөө	-	-	-	100.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010 MNS 5078: 2001 Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
2.		Химийн бодис материалын хадгалалтын нөхцлийн стандартыг нарийн баримтлаж уурших, халах, тэлэх нөхцлөөс бүрэн сэргийлж ажиллах		-	-	-		Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 6458:2014 Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага
Усны нөөц, чанар									
3.	Лабораторийн хаягдал усанд зохих саармагжуулалт, халдваргүйжүүлэлт хийлгүй төвлөрсөн шугам сүлжээгээр зайлуулснаас	Химийн бодис агуулсан шингэн хаягдлыг халдваргүйжүүлсний дараа усаар шингэлэн бохир усны сүлжээнд нийлүүлэх	Лабораторийн хаягдал усанд	-	Төслийн хэрэгжих үед	-	300.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Усны чанар ба хаягдал бохир ус. MNS 4943-2014 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, 14.2.1, 14.2.2, 14.2.4-р зүйл заалт
		Ажилчдад зориулан усаа хэмнэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулах	Усны эх үүсвэр дээр	-	Төслийн хэрэгжих үед	-	-		

	усны чанарт сөрөг нөлөө үзүүлнэ.								
4.	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь ахуйн хог хаягдал, лабораторийн хаягдал угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газрын доорх усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж бохирдуулах	Ахуйн хог хаягдал болон лабораторийн шингэн хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хадгалалтад тогтмол хяналт тавих асгарч алдагдсан тохиолдолд ашиглах шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Химийн бодисын сав баглаа боодол хадгалах цэг Хогийн цэгийн орчим Лабораторийн шингэн хаягдал хадгалах агуулах	-	-	-	200.0	Тухайн бэлтгэсэн хэрэгсэл, материал дуусах болон ашиглалтаас гарах бүрд	Усны тухай хууль, 22.1, 23.1, 24.1 зүйл заалт
Хөрс, ургамлан бүрхэвч									
5.	Химийн бодис тээвэрлэх, зөөх, хадгалах үед санамсар болгоомжгүй байдлаар химийн бодис их хэмжээгээр асгарсан тохиолдолд хөрс бохирдоно.	-Бодис их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах -Асгарсан тохиолдолд MSDS-д заасны дагуу	Химийн бодис тээвэрлэх, зөөх, хадгалах үйл ажиллагааны үед	Төслийн үйл ажиллагааны жил бүрийн урсгал зардалд тусгаж ажиллах тул зардал тусгайлан төлөвлөөгүй болно.				Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5859:2018 "Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ" Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MNS 5914:2008; Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага. MNS 5918:2008;
6.	Хөрсний болзошгүй бохирдол	Ахуйн хог хаягдлыг ангилан хадгалах, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж байх	Хогийн цэгийн орчим	Төслийн үйл ажиллагааны жил бүрийн урсгал зардалд тусгаж ажиллах тул зардал тусгайлан төлөвлөөгүй болно.				Төсөл хэрэгжих хугацаанд	MNS 5859:2018 "Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ"
Нийт төсөв				600.0					

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээн ий цар хэмжээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүл эх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Эзэмшил газарт орчны тохижилтыг хийж хатуу хучилттай автомашины зогсоол болон явган хүний зам байгуулж, лабораторийн урд талбайд мод тарьсан байгаа тул ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг хийх	Ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг сайн хийж услаж, ургуулах ажлыг ажилчдад хариуцуулан гүйцэтгүүлнэ.	Ногоон байгуулам жийн усалгаа	Удаа	30	-	25.0	Зуны турш	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага, MNS 5916-2008
2.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд ногоон байгууламжтай байхаар үүрэгжүүлсэн байдаг тул газар эзэмшигчтэй хамтран олон наст ургамлын үр тарьж ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх			-	-	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага, MNS 5916-2008
Нийт							25.0		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн дурсгал	Эзэмшил талбай орчимд археологийн дурсгал илэрсэн тохиолдолд авран хамгаалах	Археологийн дурсгал илэрвэл авран хамгаалах	-	-	Тухайн үед үйл ажиллагааны зардлаас	Төсөл хэрэгжих хугацаанд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Палеонтологийн дурсгал	Эзэмшил талбай орчимд палеонтологийн дурсгал илэрсэн тохиолдолд авран хамгаалах	Палеонтологийн дурсгал илэрвэл авран хамгаалах	-	-		Төсөл хэрэгжих хугацаанд	Газрын тухай хууль
Нийт зардал						-		

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	ХАБЭА-ны дүрэм журам зөрчигдөж осол гарах	Ажилчдыг ажлын хувцас, багаж хэрэгслээр хангах	Ажилчдад	Жил бүр компанийн үйл ажиллагааны зардалд тусгана.			Төсөл хэрэгжих хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, <u>Гамшгаас хамгаалах тухай хууль</u> Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам Галын аюулгүй байдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага MNS0641:1989 Гал эсэргүүцэх техник. Үндсэн төрөл
2.		Ажлын байранд анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулж, эм хэрэгслийн хугацааг шалгаж шинэчилж байх	Ажлын байранд	20.0				
3.		Ажиллагсдад ХАБЭА, БО-ы сургалт явуулах	Ажилчдад	Жил бүр компанийн үйл ажиллагааны зардалд тусгана.				
4.		Ослын үед ажиллах ИТА-ын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажилчдад танилцуулах	Ажилчдад			-		
5.	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх	Гал хорны ажиллагааг тогтмол шалгаж тэмдэглэл хөтлөхөөс гадна хугацаа дууссан үед шинэчилж байх	Ажлын байранд	20.0				
6.	Химийн бодисын аюулгүй ажиллагаа зөрчигдөх	Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явуулах өрөө тасалгаа, агуулахад хоорондоо үл зохицох(хамтад нь хадгалж болдоггүй) бодисуудыг хамт хадгалахгүй байх	Лаборатори йн орчинд			-		
7.		Бодисын хадгалалт хамгаалалтын аюулгүй ажиллагааны дүрмийг сахих, алдагдах нөхцлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хяналт байнга тавих	Лаборатори йн орчинд			-		

8.	Осол эрсдлээс хамгаалах ажлын ихэнх нь лабораторийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой тул гэнэтийн ослын эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэх	Ажлын байранд	Магадлашгүй зардлыг жил бүр санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж байх		
Нийт зардал			40.0		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, түр хогийн цэгт цуглуулан тээвэрлэгчид хүлээлгэн өгөх ба дахин ашиглагдах боломжтой хэсгийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	20.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль
2.		СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлыг тээвэрлэх гэрээг жил бүр шинэчлэн хийж хог хаягдлыг тус гэрээний дагуу ачуулах	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	Гэрээний дагуу	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль
3.		Зориулалтын цэгээс өөр газарт хог хаягдал хаяхгүй байхаас гадна лаборатори орчимд үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж байх	Лаборатори болон түүний ойр орчимд	Удаа	-	-	60.0	Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
4.		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Лабораторийн ажилчдад	-	-	-	20.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг Тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
5.	Үйлдвэрийн	Лабораторийн үйл ажиллагаанаас гарсан бохир усыг саармагжуулан төвийн шугамд нийлүүлэх	Төслөөс гарах шингэн хаягдал	-	-	-	-	Төсөл хэрэгжих хугацаанд	
6.	Аюултай	Лабораториос гарах химийн бодисын сав, баглаа боодол, хуруу зай, цахилгаан хэрэгслийн хаягдал зэрэг аюултай хог хаягдал гарах ба үүнийг “Цэцүүх трейд” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулах, жил бүр гэрээг шинэчлэн хийж аюултай хаягдлыг тусад нь хадгалж хог тээвэрлэгч байгууллагад хүлээлгэж өгч байх	Төслөөс гарах аюултай хог хаягдлын хэмжээнд	-	-	-	100.0	Төсөл хэрэгжих хугацаанд	
Нийт зардал							200.0		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Байгаль орчны бүрдлүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян. төг	Нийт зардал, мян. төг	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		1	2	3	4	5	6	7	8
1	Агаар	Гаднах орчны агаар дахь тоосны хэмжээ(TSP), Азотын давхар исэл(NO ₂) Хүхрийн давхар исэл(SO ₂) Нүүрсхүчлийн хий(CO)-ийн агууламж	Лабораторийн дотоод болон гадаад орчинд	Жилд 1 удаа	1	-	150.0	БОХЗТЛабораториор	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ MNS 4990:2010 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага
2		Ажлын байрны дуу шуугиан	Лаборатори дотор		1	-	50.0		
3	Усан орчин	Лабораторид хэрэглээнээс гарсан хаягдал усанд бохирдлын шинжилгээ хийх	Төвийн шугам	Жилд 1 удаа	1	50.0	50.0	БОХЗТЛабораториор	MNS 0900:2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
4	Хөрс, ургамлан нөмрөг	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O)	Лабораторийн хашаанд	Жилд 1 удаа	1	30.0	30.0	БОХЗТЛабораториор	MNS3298:1991Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага. Хөрс бохирдуулагч элемент MNS 5850:2016
5		Хүнд металлын агууламж	Лабораторийн хог хаягдлын цэгийн орчимд	Жилд 1 удаа	1	50.0	50.0	БОХЗТЛабораториор	
Нийт							330.0		

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян. төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2		6	7
1.	Орон нутгийн засаг захиргаа болон байгаль орчны байцаагчидтай байнгын харилцаа холбоотой ажиллах	-	Төсөл хэрэгжих хугацаанд	Захирал	Байгаль хамгаалах тухай хууль
2.	Хог хаягдал зайлуулах, ус ашиглах, бохир ус зайлуулах гэрээ, газрын гэрээ зэргийг сунгуулж холбогдох төлбөрийг хугацаанд төлж байх	Гэрээний дагуу	Төсөл хэрэгжих хугацаанд	Захирал	Байгаль хамгаалах тухай хууль
3.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх	Мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу	2022, 2024 онуудад	Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ дэх заалт; БОАЖС-ын 2019 оны А-809 тоот тушаал
4.	Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах	-	Жил бүр	Захирал	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
5.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулж БОАЖЯ-аар хянуулан баталуулах	500.0	Жил бүр	Захирал	
6.	Хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях, усыг зохистой хэрэглэж, хэмнэх зэргээр байгууллагын хэмжээнд холбогдох арга хэмжээнүүд авч ажиллах	-	2025 он	Захирал	Хог хаягдлын тухай хууль
7.	Байгаль орчныг хамгаалах анхааруулга, санамжийн хуудас бэлтгэж, зохих газруудад байрлуулах	-	2025 он	Захирал	Байгаль хамгаалах тухай хууль
8.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон БОМТөлөвлөгөө, ОХШХөтөлбөр, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээний зөвлөмжид тусгасан арга хэмжээг ажилчдад хариуцуулж, биелэлтийг хангах	-	Жил бүр	Захирал	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль ХАБЭА-н тухай хууль
Нийт зардал		500.0			

АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Нарт ШУҮН Консалтинг” ХХК нь “Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-ийн төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд хүргүүлэх ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж оролцоно.

Хүснэгт 9. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	23-р хорооны ИНХ	БОМТ-ий тайлан албан бичгээр хүргүүлэх		3-4-р улиралд	50.0	Захирал	СХД-ийн 23-р хорооны ЗДТГ
2.	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээллэх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	3-4-р улиралд	50.0	Захирал	СХД-ийн 23-р хорооны ЗДТГ
Нийт					100.0		

**ДҮГНЭЛТ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ
ЗАРДАЛ**

Хүснэгт 10. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Зардлын ангилал	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	600.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	25.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	40.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	200.0
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	330.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	100.0
Нийт төсөв, мян.төг		1795.0

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **1795.0 мянган төгрөг** зарцуулах урьдчилсан тооцоо гарлаа.